

Үнэт цаасны хорооны 2003 оны 3  
дугаар сарын 21-ний өдрийн 20  
дугаар тогтоолоор батлав.

## ТЕНДЕР САНАЛ ГАРГАХ, ДҮГНЭХ ТУХАЙ ЖУРАМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Хувьцаат компанийн нийтэд санал болгож гаргасан энгийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт бусад хувьцаа эзэмшигчээс худалдан авахыг хүссэн, эсхүл “Компанийн тухай” хуулийн 57.2, */Үнэт цаасны хорооны 2005 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 58 дугаар тогтоолоор нэмсэн/* 58.1-д заасан үүргээ хэрэгжүүлэн компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авахаар санал болгож буй этгээд хуульд заасны дагуу тендер саналыг зарлах, нийтэд сурталчлах, тендер саналтай холбогдсон мэдээллээр сонирхогчдыг хангах, үр дүнг тайлагнах ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

Хувьцаат компани зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн ХХК болох гэж байгаа бол энэ тухайгаа бусад хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж, тендер санал зарлаж дүгнэсэн байна.

### ХОЁР. Тендер саналыг Хороонд ирүүлэх, хүлээн авах

2.1. Тендер санал гаргахыг хүссэн этгээд хавсралт А1-6 маягтаар Хороонд өргөдөл гаргаж энэхүү журамд заасан баримтыг хавсаргасан байна.

2.2. Хороонд ирүүлсэн баримт бичгийг битүүмжилсэн байна.

2.3. Тендер санал гаргахаар ирүүлсэн баримт бичгийн агуулга зөрчилтэй, хууль тогтоомж, журамд нийцээгүй бол Ажлын албанаас буцаана.

2.4. Өргөдөлд тендер санал хүчинтэй байх хугацаа, худалдан авах хувьцааны төрөл, тоо ширхэг, үнийг заана.

2.5. Дараахь бичиг баримтыг өргөдөлд хавсаргасан байна.

2.5.1. Тендер санал гаргагчийн танилцуулга,

2.5.2. Монгол улсын хууль тогтоомжид заасан хураамж төлсөн баримт.

2.5.3. *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.8 дахь заалт, энэхүү журмын 2.7-д заасан мэдэгдлийг холбогдох этгээдэд илгээсэн, хүлээлгэн өгсөн тухай баримт /баталгааг шуудангаар явуулсан, эсхүл тухайн этгээд уг мэдэгдлийг хүлээн авсан баримт/;*

*/2005 оны 10 дугаар 13-ны өдрийн 58 дугаар тогтоолоор нэмсэн/*

2.6. Танилцуулгад дараахь зүйлсийг тусгана. Үүнд:

2.6.1. Тендер санал гаргагчийн нэр, хаяг, орших газар, утас, факс, шуудангийн хаяг;

2.6.2. Тендер санал гаргагчийн товч түүх, бүтэц, зохион байгуулалт, үйлдвэр үйлчилгээний гол чиглэл, нэр төрөл, хэмжээ, бусадтай хийсэн томоохон гэрээ хэлцэл;

2.6.3. Тендер санал гаргасан зорилго;

2.6.4. Тендер санал гаргагч ямар нэгэн компанийн хяналтын багцаас дээш хувийг өмчилдөг бол энэ тухай танилцуулга;

2.6.5. Өөр компанийн хувьцааг эзэмшиж байгаа бол тэр тухай мэдээлэл.

2.7. Тендер санал гаргагч нь тухайн компанийн нийт хувьцааны 10 ба түүнээс дээш хувийг өмчилж байгаа этгээд болон компанийн удирдлагад тендер санал гаргах тухайгаа бичгээр заавал мэдэгдсэн байна.

2.8. Хэрвээ шаардлагатай гэж үзвэл Хороо тендер санал гаргагчаас нэмэлт мэдээ, баримт бичиг гаргуулан авах, аливаа баримт бичгийг баталгаажуулахыг шаардаж болно.

2.9. Анхны тендер санал гаргагчийн хүсэлтийг шийдвэрлэсний дараа өдрөөс тухайн компанитай холбогдсон өөр тендер санал гаргагчийн мэдэгдэл баримт бичгийг Хороо хүлээн авна.

#### ГУРАВ. Тендер саналыг хэлэлцэн шийдвэр гаргах

3.1. Өргөдөл, танилцуулга, бусад баримт бичгийг хүлээн авсан, эсхүл нэмж шаардсан материалыг бүрэн бүрдүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор Хороо шийдвэр гаргана.

3.2. Тендер санал гаргагчийн төлөөлөгчид Хорооны хуралдаанд хүсэлтээ танилцуулж болно.

3.3. Тендер санал гаргагчийн хувьцаа худалдан авахаар санал болгож буй доод үнийг тухайн хувьцааны сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханш, тендер санал гаргагч тухайн хувьцааг худалдан авсан дээд ханш хоёрын аль өндрөөс доошгүй байхаар тогтооно. Харин тендер саналын үнэ нь уг хувьцааны нэрлэсэн үнээс доошгүй байж болохгүй.

3.4. Тендер саналын хүчинтэй байх доод хугацаа ажлын 60 хоног, дээд хугацаа 6 сар байна. Тендер санал гаргагчийн хүсэлтээр Хороо тендер саналын хугацааг сунгаж болно.

3.5. *Аль нэг хувьцаат компанийн хувьцааг худалдан авахаар зарласан тендер санал хүчинтэй байгаа хугацаанд уг тендер саналын үнээс доош үнээр тендер санал гаргахаар ирүүлсэн хүсэлтийг өмнөх тендер саналын хугацаа дууссанаас хойш шийдвэрлэнэ.*

*/2005 оны 10 дугаар 13-ны өдрийн 58 дугаар тогтоолоор нэмсэн/*

#### ДӨРӨВ. Тендер саналыг нийтэд зарлах, сурталчлах, арилжаа явуулах

4.1. Тухайн тендер саналыг зөвшөөрсөн шийдвэрээ Хороо нийтэд болон Хөрөнгийн биржид мэдэгдэнэ. Хөрөнгийн бирж Хорооны шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан брокер дилерийн бүх компанид мэдэгдэнэ.

4.2. Тендер санал гаргагч энэ тухайгаа хувьцаа эзэмшигчид хүргэх, нийтэд сурталчлах ажлыг хариуцна. Тендер саналыг гаргахыг зөвшөөрсөн Хорооны шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор сурталчилгааг эхэлсэн байна.

Тендер саналаа нийтэд сурталчлахдаа хавсралтаар баталсан А1-7 маягтын загварыг баримтална.

4.3. Сурталчилгааг өдөр тутмын 2-оос доошгүй сонинд нийтлүүлж, Монголын радио болон үндэсний телевизээр тус бүр ~~1-ээс доошгүй~~ 2-оос доошгүй удаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдэд аль болох богино хугацаанд хүргэх арга хэмжээ авна.

*/2005 оны 10 дугаар 13-ны өдрийн 58 дугаар тогтоолоор өөрчилсөн/*

4.4. Тендер санал гаргагч этгээд сурталчилгааны явцад өрсөлдөгчийн нэр хүндийг гутаах, хуурамч мэдээлэл тараах, гүтгэлэг хийхийг хориглоно.

4.5. Үнэт цаас гаргагч болон төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага нь тендер санал гаргагчдыг “Компанийн тухай” хуульд заасан мэдээллээр адил тэгш хангана. Тендер санал гаргагч тухайн компани болон төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагаас мэдээлэл гаргуулж авах хүсэлтээ Хороогоор дамжуулан тавьж болно.

4.6. Тендер санал гаргагчийн үнэт цаас худалдан авах захиалгыг биелүүлэхдээ “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 21.4 дэх заалтыг үндэс болгоно.

4.7. Тендер саналын сурталчилгааг эхэлсэн үед санал гаргагч нь нэг буюу хэд хэдэн үнэт цаасны компанид үнэт цаас худалдан авах захиалга өгч төлбөр тооцооны байгууллага дахь дансандаа захиалга биелүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгө төвлөрүүлсэн байна.

#### ТАВ. Хориглох зүйлс, тендер саналын биелэлтэд хяналт тавих

5.1. Хорооны шийдвэр гарсан өдрөөс хойш түүнийг хүчинтэй байх хугацаанд тендер саналыг өөрчлөхийг хориглоно.

Тендер санал гаргагч нь арилжааны явцад үнийн саналаа өсгөж болно. Харин зарласан үнийн доод хязгаараас бууруулж болохгүй.

~~5.2. Тендер саналын хэрэгжилтэд Хорооны Ажлын алба хяналт тавина:~~

~~5.2.1. Тендер санал зарлагч нь энэ журамд заасны дагуу саналаа нийтэд сурталчилсан байдал, мөн энэ журмын 6.1-д заасан шаардлагыг биелүүлсэн эсэх;~~

~~5.2.2. Тендер саналыг зарласны дараа тухайн үнэт цаасны захиалга арилжаа хэрхэн явагдаж байгаа;~~

~~5.2.3. Тендер саналтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдээс Хороонд ирүүлсэн өргөдөл, санал гомдол.~~

5.2. Тендер саналын хэрэгжилтэд дараах байдлаар хяналт тавина:

5.2.1. Тендер санал зарлагч нь энэ журамд заасны дагуу саналаа нийтэд сурталчилж байгаа эсэх, тендер санал зарласны дараах тухайн үнэт цаасны арилжааны явц, тендер саналтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд Хорооны Ажлын алба;

5.2.2. Хувьцаа худалдан авахад шаардагдах мөнгөө төвлөрсөн хадгаламж дахь дансандаа байршуулсан эсэхэд “ҮЦТТХТ” ХХК;

5.2.3. Хувьцаа худалдан авах захиалгаа зуучлуулж буй брокер, дилерийн компанид өгсөн эсэх, захиалга нь арилжааны сүлжээнд байршсан эсэхэд “МХБ” ХК тус тус хяналт тавина.

*/2005 оны 10 дугаар 13-ны өдрийн 58 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

5.3. Энэхүү журмын 4.7-д заасан хугацаанд үнэт цаас худалдан авах захиалгаа өгөөгүй, төлбөр тооцооны байгууллага дахь дансандаа мөнгөн хөрөнгө төвлөрүүлээгүй бол энэ нь тендер саналыг хүчингүйд тооцох үндэслэл болж, Хорооны ажлын алба тендерийг хүчингүйд тооцох тухай саналыг Хорооны хуралдаанд оруулан шийдвэрлүүлнэ.

5.4. Энэ журмын 5.2.2, 5.2.3-д заасан шаардлагыг тендер санал гаргагч биелүүлсэн эсэх талаар тендер санал хүчинтэй болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор “ҮЦТТТХТ” ХХК, “МХБ” ХК нь Хороонд мэдээлнэ.

*/2005 оны 10 дугаар 13-ны өдрийн 58 дугаар тогтоолоор нэмсэн/*

ЗУРГАА. Тендер саналын биелэлтийг дүгнэж тайлагнах, хариуцлага хүлээлгэх

6.1. Тендер саналын хугацаа дуусмагц тендер санал гаргагч тухайн хугацаанд хувьцаа худалдан авсан тухай тайланг хавсралт А1-8 маягтаар гаргаж Хороонд ирүүлсний дараа Бүртгэл санхүү, оруулалтын хэлтсийн уг асуудлыг хариуцан оруулсан мэргэжилтэн тогтоолын биелэлтийг дүгнэж Мэдээлэл, дотоод ажлын тасагт өгнө.

6.2. Энэ журмын заалтыг зөрчсөн этгээдэд “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 38.1.1 дэх хэсэгт заасан захиргааны шийтгэл ногдуулна.

~~6.3. Хуульд заасан журмын дагуу тендер саналаа зарлаагүй, зарласан боловч энэхүү журмын 4.7-д заасан шаардлагыг биелүүлээгүй, бусад хувьцаа эзэмшигчдийг хууран мэхлэх ажиллагаа явуулсны улмаас тендер санал нь хүчингүй болсон бол тендер зарлагчийн эзэмшиж буй хувьцаа нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх хүртэл хугацаанд саналын эрхгүйд төөцөгдөнө.~~

6.3. Тендер санал зарлах үүрэг бүхий этгээд хуульд заасан журмын дагуу тендер санал зарлаагүй, зарласан боловч энэ журмын 4.7-д заасан шаардлагыг биелүүлээгүй, хувьцаа эзэмшигчдийг хууран мэхлэх ажиллагаа явуулсны улмаас тендер санал нь энэ журмын 5.3-т зааснаар хүчингүй болсон бол Компанийн тухай хуулийн 58.2-т зааснаар тухайн этгээдийн эзэмшилд буй хувьцаа саналын эрхгүйд тооцогдоно. Энэ талаар Хороо “ҮЦТТТХТ” ХХК болон олон нийтэд мэдээлнэ.

*/2005 оны 10 дугаар 13-ны өдрийн 58 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

МОНГОЛ УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНД  
ӨРГӨДӨЛ ГАРГАХ НЬ:

----- компанийн -----  
хувьцааны -----хувийг/ширхэг/ -----  
-----/байгууллагын нэр, эсхүл  
нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн овог, нэр/ өмчилж байгаа бөгөөд түүн дээр уг хувьцааны -  
----- хүртэл хувийг нэмж нийт ----- хувийг өмчлөхөөр тендер санал зарлах хүсэлтээ  
гаргав.

1. Тендер санал гаргахыг хүсэгчийн:

а/нэр -----  
/хэрэв иргэн бол овог, нэр/  
б/хаяг -----  
орших газар -----  
/хэрэв иргэн бол эрхэлдэг ажил, албан тушаал/  
в/Улсын бүртгэлийн гэрчилгээний  
дугаар ----- регистр -----  
/иргэн бол иргэний үнэмлэхний дугаар -----  
регистр -----/

2. Худалдан авах хувьцааны нэрлэсэн үнэ -----
3. Санал болгож буй үнэ -----
4. Худалдан авах хувьцааны тоо, ширхэг -----
5. Хувьцаа худалдан авах мөнгөн хөрөнгийн дүн -----
6. Тендер саналын хүчинтэй байх хугацаа -----
7. Хороонд ирүүлсэн баримтын үнэн зөв эсэх, өөрт тохиолдож болзошгүй эрсдлээс учрах хохирлын хариуцлагыг Монгол улсын Үнэт цаасны хороотой хуваалцахгүйг батлан илэрхийлж байна.

Өргөдөл гаргасан: -----  
/албан тушаал, тамга/

200. оны .. дугаар  
сарын ..-ны өдөр

ТЕНДЕР САНАЛЫГ СУРТАЛЧЛАХ ЗАГВАР

1. "Үнэт цаасны зах зээлийн тухай" Монгол улсын хуулиас:

-3.1.14. "Тендер санал гаргах" гэж тогтоосон журмын дагуу нээлттэй хувьцаат компанийн энгийн хувьцааны хяналтын багц буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд худалдан авах саналаа нийтэд зарлахыг хэлнэ.

-11.1. Тендер саналыг энэ хууль болон түүнд нийцүүлэн Хорооноос тогтоосон журмын дагуу гаргана.

-11.5. Тендер саналын хүчинтэй байх доод хугацаа ажлын 60 хоног, дээд хугацаа 6 сар байна.

-11.7. Тендер санал гаргагч тендер саналтай холбогдсон мэдээллийг сонирхогч бүх этгээдэд нэгэн адил хүргэх үүрэгтэй.

2. Тендер санал гаргагч байгууллагын оноосон нэр, хаяг/иргэн бол овог, нэр/  
-----

3. Үнэт цаасны хорооноос тендер санал гаргахыг зөвшөөрсөн огноо, Хорооны шийдвэрийн агуулга -----

1. Компанийн нэр хаяг, гаргасан хувьцааны тоо ширхэг, нэрлэсэн үнэ  
-----

2. Тендер санал зарлагдаж байгаа компанийн сүүлийн 3 жилийн эдийн засгийн үзүүлэлтүүд:

борлуулалт: 200. -----

200. -----

200. -----

ашиг: 200. -----

200. -----

200. -----

Нэгж хувьцаанд олгохоор зарласан ногдол ашиг:

200. -----

200. -----

200. -----

1. Худалдан авахаар санал болгож буй хувьцааны тоо ширхэг, нийт хувьцаанд эзлэх хувь  
-----

2. Нэг ширхэг хувьцааг худалдан авах тендер саналын үнэ  
-----

3. Тендер санал зарласан хувьцаа эзэмшигчийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл  
-----

4. Өөр компанийн хувьцааг эзэмшиж байгаа бол тэр тухай мэдээлэл  
-----

Тендер саналын талаар мэдээлэл авч болох хаяг, утас---

Нэгдмэл сонирхолтой этгээдийг төлөөлөх этгээдийн овог, нэр, хаяг, утас -----

ТЕНДЕР САНАЛЫН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Тендер санал гаргагч:

НЭР

ДАНС

-----  
-----

-----  
-----

Ямар хувьцаат компанийн хувьцаа болох -----

Худалдан авахаар санал болгосон үнэ -----

Худалдан авахаар зарласан

хувьцааны тоо ширхэг -----

Хувьцаа худалдан авахад шаардагдах

мөнгөн хөрөнгийн дүн-----

Тендер санал: эхлэх -----

дуусах ----- хугацаа

Тендер саналын хүчинтэй байх хугацаанд

Тендер зарлагчдын

дансанд орсон мөнгөн хөрөнгийн дүн -----

Огноо	Данс	Худалдан авсан		Мөнгөн дүн	Шимтгэл	Нийт мөнгөн дүн	Хэлцлийн дугаар
ДҮН							

Мөн хугацаанд тухайн хувьцааг эзэмшигчдээс

худалдахаар захиалсан тоо ширхэг -----

дундаж үнэ -----

/Энэ хэсгийг Хөрөнгийн биржийн холбогдох ажилтан нөхөн гаргаж гарын үсэг, албаны тэмдэгдарсан байна/.

Биелэлтийн тайлан гаргасан /

/

Тайланг шалгаж баталсан:

Төлбөр тооцооны байгууллагын

Ажилтан

/

/

Тайланг хүлээн авсан:

Хорооны ажилтан

/

/

Огноо -----